

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 04-р сарын 09

Улаанбаатар хот

“Барилга” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ байгууллагын хурлын танхимд ТУЗ-ын нарийн бичгийн дарга хурлын ирц танилцуулсанаар 10.25 цагт гишүүдийн 98.6 хувийн ирцтэй эхлэв. Хуралд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ын хараат бус гишүүд оролцов.

ХЭХ-ыг ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа нээж хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ТУЗ-с гаргасан тогтоол, хурлын дэгийг танилцуулав. Дэгийг 100 хувь батлав. Хувьцаа эзэмшигч Г.Болд өвчтэй байсан тул хурлын тэргүүлэгчээр Г.Буд, Л.Шагдаррагчаа, С.Сүхбаатар нарыг томилов.

Хуралд оролцогсод бүх тайлантай танилцсаны дараа асуулт хариулт, санал шүүмжлэлүүдийг хэлэлцэхээр тогтов.

ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа ТУЗ-ын тайланг уншиж танилцуулав. Тайланг хавсаргасан болно.

Үүний дараа НяБо А.Мөнхцоож 2015 оны санхүүгийн тайланг танилцуулав. Дөлгөөн Хайрхан Уул Аудитын дүгнэлтийг болон аудитороос өгөгдсөн зааварчилгаа, зөвлөмжүүдийг мөн уншиж танилцуулав. Зааварчилгаа зөвлөмжүүдийн дагуу өгөгдсөн хариулт, тайлбаруудыг давхар танилцуулав.

Дараагийн ээлжинд Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат байгууллагын тайлант оны үйл ажиллагааны үр дүн болон ирэх оны үйл ажиллагааны чиглэлийн талаархи тайланг уншиж танилцуулав. Тайланг хавсаргав.

10.50-д хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал нэмэгдэж ирэв.

Бүх тайлангууд танилцуулагдсаны дараа асуулт хариулт руу шилжив:

Г.Буд: Ил тодын тайлангийн дараа үл хөдлөх хөрөнгө дээр нэмэгдсэн зүйл бий юү?

НяБо А.Мөнхцоож: Мөнгөн хөрөнгө нэмэгдсэн, үл хөдлөх хөрөнгө нэмэгдээгүй. Өмнө нь хөрөнгө оруулалт гэж балансад бүртгэгдсэн байсаныг мөнгөн хөрөнгө болгож харуулсан. Бичилт хийж хөрөнгийг ил болгосон гэсэн үг.

Ш.Эрдэнэбат: Дашрамд хэлэхэд СУИС-ийн хойно байрладаг байсан барилгыг буулгасан ба энэ харин үл хөдлөх хөрөнгөөс хасагдана.

Г.Буд: Тэр барилга анх хэдэн төгрөгийн өртөгтэй байсан бэ?

А.Мөнхцоож: 323,3 сая төгрөг байсан.

Ш.Үнэнбат: НӨАТ дээр гарсан зөрчлийн талаар юу болсон бэ?

А.Мөнхцоож: Мөрдөн дээр байгаа.

Ш.Үнэнбат: Ийм зөрчлийн тал дээр прокуророос нөхөн татвар төл гэсэн бичиг явуулж байгаа гэсэн. Энийг судлаж үзэв үү?

А.Мөнхцоож: манайд одоогоор тийм бичиг ирээгүй байгаа. Хэрвээ илвэл хуулийн дагуу асуудалыг шийдвэрлэнэ.

С.Тунгалаг: Ил тодын хуулийн дагуу татварыг нөхөн төлөхгүй харин нийгмийн даатгалыг л ганцхан төлөхөөр байгаа.

Ш.Үнэнбат: СУИС-ийн хойно байрладаг байсан буулгасан барилгын түрээсийг хэдэн сар хүртэл аваагүй байсан бэ? Тэрийг баланс дээр юу гэж тусгасан бэ? Компанийн эрсдэл гэж үзэж байгаа юм уу?

А.Мөнхцоож: Хаан зам ХХК нь 2015 онд огт төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдож хамгийн сүүлд 2014 оны үлдэгдэлийг өөрийн байрыг барьцаалж зээл авч төлж дуусгасан. Иймээс Хаан зам ХХК төлбөрийн чадваргүй гэж үзээд 2015 онд тус түрээсийн орлого болон авлага болгон тусгаагүй. Үл хөдлөхийн хөрөнгийг балансын бүртгэлээс 2016 оны 1-р улиралд хасаж Чингэлтэй дүүргийн татвараас үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлхөөр ажиллаж байна.

Өөр асуулт гараагүй тул саналын хэсэг рүү шилжив.

Л.Шагдаррагчаа: Та бүхэн түрүүний миний илтгэл дээр анзаарсан бол компанийн өөрийн үл хөдлөх хөрөнгийг шинэчлэх, мууг нь буулгаж шинэ 16 давхар Бизнес үйлчилгээний төв бариулахаар зураг хийлгэсэн талаар дурдсан. Барилгыг буулгаж дууссан. Газар шорооны ажил нь өнөө маргаашаас эхлэнэ. Мөн Авто худалдааны цогцолборыг барих газрыг дуудлага худалдаагаар авсан. Гэр хорооллын барилгажилт дээр мөн 538,4 сая төгрөг зарцуулчихаад байна. Суурь каркасыг нь хийх төлөвлөгөөтэй байна. Компани маань ямар нэгэн өр зээлгүй цэвэр байгууллага байгаа юм. МУИС-ийн Е-номын сангийн ажлыг ч гэсэн ашигттай хийнэ гэж үзэж байна. Эдгээр ажлуудыг хийх хөрөнгөний 50%-ийг компани өөрөө гаргаж чадна.

Ш.Үнэнбат: Надад санал байна:

- Дотоодын нөөц бололцоогоо ашиглаад Бизнес үйлчилгээний төв, Авто худалдааны цогцолборыг барихад компанийн өөрийн нөөц 50%-ийг нь хангана гэж байна. Аккредитив зээлийн асуудлыг судлаж үзэх нь зөв байх, маш бага хүүтэй. Банкаар дамжуулан Хятадын банкнаас барилгын ажилд хэрэглэх материалуудыг маш бага хүүтэйгээр авах боломжтой юм байна. Бэлэн мөнгөөрөө цалингаа тавиад материалуудаа ийм замаар зохицуулах талыг бодолцоорой.

Г.Буд: Тус компанийг байгуулагдаад 20 жил болсон байна. Анх ямар байсныг бид бүгд мэдэж байгаа. Одоо энэ өндөрлөгөөс харахад сайхан л байна. 2016 онд сайн судлаж үзээд эрсдэл багатай зүйлд хөрөнгө оруулалт хийгээсэй гэж хүсэж байна.

Эдийн засгийн байдал 2016 онд муудаж магадгүй. Ер нь их хөрөнгө цацахгүй болгоомжтой хандсан нь зөв.

Б.Энхболд: Буд гуайтай санал нэг байна.

Ш.Эрдэнэбат: Бизнес төвийг орон сууц болгохгүйгээр СУИС-ийн хажууд байгаа тул оюутнуудад түрээслүүлэх байр болгох бодол мөн байгаа.

Г.Буд: Ингэх нь эрсдэл давхар дагуулдаг, дотор нь байршуулсан тавилгуудыг эвдэж сүйтгэх явдал их гарна. Тогтвортой түрээслэгчтэй байхгүй бол. Урсгал зардал их гардаг.

Л.Шагдаррагчаа: Их зүйтэй саналууд хэлж байна. Цаашид анхааръя.

Саналуудын дараа гарах тогтоолын төслүүдэд санал хурааж тарааж өгсөн саналын хуудсуудыг хурааж авав. Тогтоол 3, 4-ийг 100 %-ийн санал нэгтэй дэмжив. Тогтоол 5 дээр тусгасан Барилгачдын талбайн засварын ажилд хуваариласан 60 сая төгрөг бага байна гэдэг Ш.Үнэнбатын саналыг харгалзан үзэж Барилгачдын талбайн засварын ажлыг хийсэн гүйцэтгэлээр нь тооцохоор тогтов. Тогтоол 6-г 100 %-ийн санал нэгтэй батлав.


Өөр санал гарсангүй, хурал 12.00 цагт дуусав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



З.КУРАЛАЙ